



МОНГОЛЫН ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООДЫН
ҮНДЭСНИЙ ХОЛБООНЫ ШАГНАЛЫН ЖУРАМ

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1. Энэхүү журмын зорилго нь Монголын хадгаламж зээлийн хоршооллын хөдөлгөөний хөгжилд бодитой хувь нэмэр оруулж буй Монголын Хадгаламж Зээлийн Хоршоодын Үндэсний Холбоо (цаашид MX3XYX)-ны гишүүн хадгаламж зээлийн хоршоо (цаашид X3X)-д, тэдгээрийн удирдлага, ажилтан, гишүүд, дэмжигчдэд цол, тэмдэг хүртээх, одон медалиар шагналуулахаар нэр дэвшиүүлэх, уламжлах, түүнийг хүлээн авч судлах, шийдвэрлэхтэй холбогдсон бүхий л харилцааг зохицуулахад оршино.
2. MX3XYX-ны шагналыг холбооны тэргүүлэгчдийн зөвлөлийн хурлын шийдвэрээр олгох бөгөөд бусад шагналыг холбогдох төрийн болон төрийн бус байгууллагаар дамжуулан Монгол улсын Ерөнхийлөгч, УИХ, Засгийн газар нэр дэвшиүүлнэ.

ХОЁР. ШАГНАЛЫН ТӨРӨЛ, БОЛЗОЛ

2.1. **“Хүндэт хоршоологч”** нь хөдөлгөөний хөгжилд оруулсан хувь нэмрийг үнэлж олгох салбарын хэмжээний дээд шагнал бөгөөд зөвхөн MX3XYX-ны тэргүүлэгчдийн зөвлөлийн санаачлага, шийдвэрээр олгоно. Энэхүү шагналаар салбарын хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулсан, 5-аас доошгүй жил салбарт үр бүтээлтэй ажиллаж байгаа, салбарын хөгжлийг дэмжигч гадаад дотоодын төрийн болон төрийн бус байгууллагад ажиллаж байгаа хувь хүн, X3X, түүний сонгуульт болон гүйцэтгэх албаны хүнийг шагнана. Шагналыг 100,000 төгрөгийн мөнгөн шагнал дагалдах бөгөөд эх үүсвэрийг MX3XYX хариуцна.

2.2. **Цол, тэмдэг** нь X3X-ны салбарын хөгжилд оруулсан үнэтэй хувь нэмрийг үнэлж тухайн хоршооны тэргүүлэгчдийн зөвлөлийн шийдвэр, тодорхойлолт, хүсэлтийг үндэслэн хоршооны удирдлага, ажилтан гишүүнд олгох шагналууд байна. Шагнал бүрт мөнгөн шагнал дагалдах бөгөөд эх үүсвэрийг нь тодорхойлсон X3X нь хариуцна.

2.2.1 “**Бичил санхүүгийн тэргүүний ажилтан**” цол, тэмдэг – X3X-ны салбарт 5-с доошгүй жил тогтворт суурьшилтай ажилласан, ажил мэргэжлээрээ өөрийн X3X-ны тэргүүний ажилтнаар үнэлэгдсэн, мэргэжлийн өндөр ур чадвар гарган эрхэлсэн ажилдаа амжилт үзүүлж, идэвхи санаачилагатай, үр бүтээлтэй ажиллаж, X3X-ны салбарын хөгжилд бодитой хувь нэмэр оруулж буй X3X-ны сонгуульт гишүүн болон гүйцэтгэх албаны ажилтанг шагнана. Шагналыг 50,000 төгрөгийн мөнгөн шагнал дагалдана.

2.2.2 “**Хадгаламж, зээлийн хоршооны хүндэт гишүүн**” тэмдэг – X3X-ныхоо хөгжилд оруулсан хувь нэмрийг нь үнэлж үүсгэн байгуулагч гишүүд, 5-аас доошгүй жилийн тасралтгүй гишүүнчлэлтэй X3X-ны гишүүнд олгож болно. Шагналыг 30,000 төгрөгийн мөнгөн шагнал дагалдана.

2.3 **Оны шилдэг номинаци** -уудыг МХЗХҮХ болон ХЗХ-доос нэр дэвшүүлэх 2 төрлөөр шалгаруулна.

2.3.1. МХЗХҮХ нь гишүүн ХЗХ-дын идэвх оролцоо, салбарт оруулж буй хувь нэмэр, өсөлт, авч хэрэгжүүлсэн арга хэмжээг үнэлж дараах “Оны шилдэг” номинацуудаар тус бүр нэг ХЗХ-г тодруулж шалгаруулна.

2.3.1.1. **Оны шилдэг ХЗХ** – Өргөмжлөл, 500,000 төгрөгийн мөнгөн шагнал

2.3.1.2. **Оны хамгийн олон гишүүн элсүүлсэн ХЗХ** – Өргөмжлөл, 250,000 төгрөгийн мөнгөн шагнал

2.3.1.3. **Оны хамгийн их актив хөрөнгийн өсөлттэй ХЗХ** – Өргөмжлөл, 250,000 төгрөгийн мөнгөн шагнал

2.3.2 МХЗХҮХ-ны гүйцэтгэх албанаас тухайн жилд холбооны үйл ажиллагаанд идэвх санаачилгатай оролцож, хувь нэмэр оруулсан 36 хүртэлх насын хоршоологчдыг нэр дэвшүүлж, тэргүүлэгчдийн зөвлөлөөр хэлэлцэн “Оны шилдэг залуу хоршоологч”ийг тодруулна.

2.3.2.1 “**Оны шилдэг залуу хоршоологч**” – Өргөмжлөл, 100,000 төгрөгийн мөнгөн шагнал

2.3.3 ХЗХ нь сонгуульт гишүүд болон гүйцэтгэх албаны ажилтнуудаа дараах номинацид нэр дэвшүүлнэ. Холбооны тэргүүлэгчдийн зөвлөл нэр дэвшигчдээс оны шилдэгүүдийг сонгон шалгаруулна.

2.3.3.1. **Оны шилдэг манлайлагч;** -Өргөмжлөл, 100,000 төгрөгийн мөнгөн шагнал

2.3.3.2. **Оны шилдэг ажилтан;** - Өргөмжлөл, 100,000 төгрөгийн мөнгөн шагнал

2.4. Оны шилдэг манлайллагчид нэр дэвшигч нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

2.4.1. ХЗХ ны Бүх гишүүдийн хурлаас сонгогдсон сонгуульт гишүүд, захирал байна.

2.4.2. Хоршооны үйл ажиллагаанд идэвх санаачилгатай, үр бүтээлтэй ажилласан;

2.4.3. ХЗХ нь зохиц харьцааны шалгуур үзүүлэлтийг сүүлийн 4 улирал дараалан биелүүлж ажилласан;

2.4.4. ХЗХ нь холбоонд татвар болон бусад төрлийн өрийн үлдэгдэлгүй байх.

2.5. Оны шилдэг ажилтанд нэр дэвшигч нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

2.5.1. ХЗХ -ны гүйцэтгэх албаны ажилтан, эсвэл зээлийн хорооны гишүүн байна.

2.5.2. ХЗХ -ны үйл ажиллагаанд идэвх санаачилгатай, үр бүтээлтэй ажилласан;

2.5.3. ХЗХ нь холбоонд татвар болон бусад төрлийн өрийн үлдэгдэлгүй байх.

ГУРАВ. ШАГНАЛД НЭР ДЭВШҮҮЛЭХ, УЛАМЖЛАХ

3.1. ХЗХ нь энэхүү журмын 2.2-д заасан нөхцөл, шаардлагыг хангасан ажилтан, удирдлага, гишүүнийг цол, тэмдэгт нэр дэвшүүлэхдээ дараах баримт бичгийг бүрдүүлж МХЗХҮХ-нд ирүүлнэ. Үүнд:

3.1.1. албан бичиг;

3.1.2. шагналд нэр дэвшигчийн ажил байдлын тодорхойлолт;

3.1.3. шагналд нэр дэвшигчийн анкет (*Хавсралт №1*);

- 3.1.4. шагналд тодорхойлогдсон үндэслэл буюу сүүлийн 5 жилийн ажлын ололт амжилт, үр бүтээл, ажлын гол үзүүлэлт, хүрсэн үр дүнгийн талаар;
- 3.1.5. шагналд нэр дэвшүүлэхээр шийдвэрлэсэн тэргүүлэгчдийн хурлын тэмдэглэл, тогтоол.
- 3.2. ХЗХ нь энэхүү журмын 2.3.3-д заасан шагналд нэр дэвшүүлэхдээ дараах баримт бичгийг бүрдүүлж МХЗХҮХ-нд ирүүлнэ. Үүнд:
- 3.2.1 Албан бичиг;
 - 3.2.2 Тэргүүлэгчдийн зөвлөлийн хурлын тогтоол;
 - 3.2.3 ХЗХ-ны танилцуулга;
 - 3.2.4 нэр дэвшигчийн анкет (*Хавсралт №1*);
 - 3.2.5 тухайн жилд хийж бүтээсэн ажил, хүрсэн үр дүнгийн тухай танилцуулга буюу нэр дэвшүүлсэн үндэслэл;
 - 3.2.6 хоршооны сүүлийн 4 улирлын санхүүгийн зохицуулах хорооны маягтаарх санхүүгийн тайлан.
- 3.3 МХЗХҮХ-ны гишүүнчлэлийн дэд хороо нь дараах үзүүлэлтээр гишүүн ХЗХ-дыг үнэлэн энэхүү журмын 2.3.1-д заасан номинациудад нэр дэвшүүлнэ.
- 3.3.1. гишүүний өсөлт;
 - 3.3.2. актив хөрөнгийн өсөлт;
 - 3.3.3. зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн биелэлтийн тухайн жилийн дундаж;
 - 3.3.4. МХЗХҮХ-ны гишүүнчлэлийн татвар төлөлт;
 - 3.3.5. МХЗХҮХ-ноос тухай жилд зохион байгуулсан ажилд оролцсон байдал;
- 3.4 Энэхүү журмын 3.3.1-3.3.5-т заасан шаардлага хангасан хоршоодоос дараах үзүүлэлтээр нэмэлт судалгаа авна.
- 3.4.1 гишүүдэд зориулсан сургалт, нийгмийн арга хэмжээнүүд зохион байгуулсан байдал;
 - 3.4.2 ХЗХ-ны санхүүгийн болон үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийн хувь.
- 3.5. Энэхүү журмын 2.3.2, 2.3.3-т заасан шагналыг холбооны шинэ жилийн арга хэмжээний үеэр гардуулна.
- 3.6 Энэхүү журмын 2.3.1-д заасан шагналыг холбооны бүх гишүүдийн хурлаар өргөмжлөл хэлбэрээр гардуулна.

ДӨРӨВ. МАТЕРИАЛ ХҮЛЭЭН АВАХ ХУГАЦАА, ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ.

- 4.1. Шагнуулахаар ирүүлсэн материалыг МХЗХҮХ-ны гүйцэтгэх алба хүлээн авч бүртгэн, Тэргүүлэгчдийн зөвлөлд танилцуулан шийдвэрлүүлнэ.
- 4.2. Энэхүү журмын 2.2-т заасан шагналд нэр дэвшүүлсэн ХЗХ нь цол тэмдэгийн хураамжийг шагнах шийдвэр гарсан даруй МХЗХҮХ-нд төлнө. Шагналын хураамжийг Холбооны тэргүүлэгчдийн зөвлөлийн хурлаас жил бүр шинэчлэн тогтооно (*Хавсралт №2*).
- 4.3. Энэхүү журмын 2.3.2, 2.3.3 – т заасан шагналд нэр дэвшүүлэхтэй холбоотой материалыг жил бүрийн 11 дүгээр сарын 30-ны өдөр хүртэл хүлээн авна.
- 4.4. Энэхүү журмын 2.2-т заасан шагналд нэр дэвшүүлэхтэй холбоотой материалыг салбарын болон тухайн ХЗХ-ны 5, 10, 15, 20, 25, 30 ... гэх мэт жилийн ойн өдрүүд, Бүх гишүүдийн хурал, Санхүү, эдийн засгийн ажилтны өдөр, бусад тэмдэглэлт өдөр, аливаа баяр болохоос 30-аас доошгүй хоногийн өмнө холбоонд ирүүлсэн байна.

- 4.5. Төрийн дээд цол тэмдэг, одон медаль болон бусад байгууллагын шагналд тодорхойлуулахаар ирүүлсэн ХЗХ-ны материалыг хүлээн авч холбогдох шалгуур, бүрдлийг хангаж байвал тухайн газарт уламжлан явуулна.
 - 4.6. Холбооны шагналд тодорхойлох ерөнхий нөхцөлийг хангаагүй, холбогдох баримт бичгийн бүрдэл дутуу, хугацаанаас хожимдуулж ирүүлсэн тохиолдолд шагналыг олгохоос татгалзах, хойшлуулах арга хэмжээг Холбоо авч болно.
 - 4.7. Холбоо шагналын нэгдсэн бүртгэлийг хөтөлж, архивлан хадгална.
-

Монголын хадгаламж зээлийн хоршоодын

Үндэсний холбооны шагналын журмын хавсралт №1

ТТГ3620 д. 8019703



Регистрийн дугаар

--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--

ШАГНАЛД НЭР ДЭВШИГЧИЙН АНКЕТ

1. Ургийн овог _____
2. Эцэг (эхийн) нэр _____ 3. Өөрийн нэр _____
3. ХЗХ-ны нэр:
4. Төрсөн он ____ сар ____ өдөр ____ 5. Хүйс _____
6. Төрсөн газар _____
7. Гэрийн хаяг _____
8. Утас _____ гэр _____ гар _____
9. Мэргэжил, боловсрол

4x6

Хаана, ямар сургууль	Орсон огноо	Төгссөн огноо	Эзэмшсэн мэргэжил, диплом, гэрчилгээний дугаар

10. Ажлын туршлага

Байгууллага (албан газрыг тухайн үеийн нэрээр)	Албан тушаал	Ажилд орсон огноо	Ажлаас гарсан огноо

11. Сонгуульт ажлын туршлага

Байгууллага (албан газрыг тухайн үеийн нэрээр)	Сонгуульт ажил	Эхэлсэн огноо	Дууссан огноо

Тэргүүлэгчдийн Зөвлөлийн Хурлын
2023 оны 11-р сарын 21 өдрийн
16 тоот тогтоолоор батлав.

12. Бүтээсэн ажил, хүрсэн үр дүнгийн тухай танилцуулга буюу нэр дэвшүүлсэн үндэслэл;

13. Дэвшүүлж буй шагнал:

14. Хамт олны шийдвэрийн хувь:

202 _____ он _____ сар _____ өдөр

Тэргүүлэгчдийн Зөвлөлийн Хурлын
2023 оны 11-р сарын 21 өдрийн
16 тоот тогтоолоор батлав.



Монголын хадгаламж зээлийн хоршоодын
үндэсний холбооны шагналын журмын хавсралт №2

Шагнал цол тэмдгийн хураамж

№	Шагналын нэр	Хураамж
1	“Хүндэт гишүүн” цол тэмдэг	30,000
2	“Бичил санхүүгийн тэргүүний ажилтан” цол тэмдэг	30,000